

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	
Стратегийн зорилт 9. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод хяналт шалгалт, аудит хийх							
1	Зорилт 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх						
1.1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна.	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах 18 зорилтын 44 арга хэмжээний хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гарган Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа. ХШҮ-ний дүнг ЗГХЭГ-т хүргүүлэн цахим мэдээллийн санд хуулийн хугацаанд сар бүр баталгаажуулсан. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа,		

					хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу 56.4 хувь үнэлэгдлээ.
1.2	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 12 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна.	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хариуцан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гарган Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хамаарах 3 хөтөлбөрийн 4 төсөл, арга хэмжээ туссан байна. Нийт үнэлгээгээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хамаарах 3 хөтөлбөр 4 төсөл, арга хэмжээ буюу Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 92.5 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.
1.3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 12 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар гарган Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хийж тайлан танилцуулгыг удирдлагад танилцуулан Хяналт-шинжилгээ үнэлгээний цахим системд хугаацаанд нь оруулан баталгаажуулсан. Тогтоол шийдвэрийн 228 заалтын хэрэгжилт 87.6 хувьтай байна.

1.4	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 дахь заалтын дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч ажиллаа. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар “Үр дүнтэй” буюу 93.3 хувьтай үнэлэгдлээ. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хүрээнд тусгасан зорилт арга хэмжээнүүдийн эрх зүй орчинг бүрдүүлэх ажлыг Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Тус бодлогын хүрээнд батлагдсан хууль, журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчин бүрдсэнээр “Төрөөс баримтлах тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.17, 3.2.18, 3.2.19, 3.2.20, 3.2.21, 3.6.4 дахь заалтууд хэрэгжиж эхлэнэ. Иймд хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт арга хэмжээнүүдийг эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байна.
1.5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн	Үнэлгээний тайлан зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/205 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга,

			хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.		тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв. Нийт үнэлгээгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилт 87.0 хувийн үнэлгээтэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.
1.6	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 20 үзүүлэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 95.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 14 үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, 6 үзүүлэлт 50.8-95.0 хувийн гүйцэтгэлтэй байна. БШУЯ-нд шилжсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын 2 үзүүлэлт үнэлэх боломжгүй байна. Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо үнэлэх боломжгүй арга хэмжээг оруулан тооцоогүй болно.
1.7	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 5 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан зөвлөмжийг удирдлагад танилцуулан СЯ-нд хүргүүлсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3 төслийн 2023 оны хэрэгжилтийг үнэлж, тайлан дүгнэлтийг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/530 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн дээрх төслүүдийн 2024 оны 1,3-р улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайлан дүгнэлтийг Төсвийн шууд захирагч болон төслийн захирал, зохицуулагч нарт хүргүүлсэн. Төслүүдийн 3-р улирлын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дараах дугаарын албан бичгүүдээр хүргүүлсэн. Үүнд:

					- 03/1125 дугаар албан бичгээр ХБИ-ийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл, - 03/1126 дугаар албан бичгээр Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл, - 03/1127 дугаар албан бичгээр Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгаалын төслийн нэгжид тус тус хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор эргэн тайлагнах чиглэл өгсөн.
1.8	ТЕЗ-ийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан СЯ-нд хүргүүлсэн байна.	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 6 хөтөлбөрийн 19 үзүүлэлт туссан байна. Нийт үнэлгээгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 88.9 хувийн биелэлттэй байна.
1.9	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын хэрэгжилтэд		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг	Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын 2024 оны хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, тайланг ТНБД, газрын даргад танилцуулан 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн Дугаар 03/644 албан бичгээр ЭЗХЯамандхүргүүлж, https://new.unelgee.gov.mn/ программд оруулж баталгаажуулан ажилласан. Алсын

	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна.	хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 2024 оны хагас жилийн байдлаар 86.07 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн.
1.10	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх нийт 5 зорилго, 8 зорилтын 20 арга хэмжээ туссан байна.
1.11	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна.	Монгол Улсын 2021-2025 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан ГБХНХЯ-нд хамаарах дараах төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайлан дүгнэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний дотор ЭЗХЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна. Үүнд: 1. Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл, 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл, 3. Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл. Төслийн хэрэгжилтийн 2024 оны жилийн эцсийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор төсөл

					хариуцсан нэгжүүдээс хүлээн авч хяналт-шинжилгээ үнэлгээг хийж байна. Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ГБХНХ-ын салбарт хамаарч байсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор” барьж байгуулах ажлыг Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 216 тогтоолоор Олимп, нийтийн биеийн тамир, спорт (ОНБТС)-ын Үндэсний хороонд шилжүүлэн хариуцуулсан байна. Үүнтэй холбоотой уг спорт цогцолборыг барьж байгуулахтай холбогдон олгосон техникийн нөхцөл, бусад баримт материалыг ОНБТС-ын Үндэсний хорооны Ажлын албанд хүлээлгэн өгсөн байна.
2	Зорилт 2. Байгууллагын үйл ажиллагаа, хамтран ажиллах гэрээний гүйцэтгэл, үр дүн, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх				
2.1	Яамны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан хүргүүлэх		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан	Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтын дагуу дүгнэхэд ерөнхий үнэлгээ 87.0 хувь буюу 4.35 оноотой байна. Үнэлгээний тайланг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн.
2.2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны

	баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2 зорилт, 7 үйл ажиллагаанд 13 шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2023 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 10, 90 хувийн биелэлттэй 3 үйл ажиллагаа байна. Нийт үнэлгээгээр Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 97.7 хувьтай байна.
2.3	Байгууллагын ил тод байдлын үнэлгээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэллээ. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 70.8 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг холбогдох газар нэгжүүдэд дотоод бичгээр хүргүүлэв. ✓ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2.-8.6-д заасан мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд Нээлттэй мэдээллийн ил тод байдлын нийт 71 мэдээллээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хамаарах 48 мэдээллийг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын 2.1.1-2.1.4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу 3.1-3.4 заасан аргачлалын дагуу оноогоор үнэллээ. 2023 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийж удирдлагуудад танилцуулан ХЗДХЯ-д цахимаар хүргүүлэв. Хяналт-шинжилгээ,

					үнэлгээгээр өгсөн зөвлөмийг хэрэгжүүлж ажиллах тухай дотоод албан бичгийг ТЗУГ-т хүргүүлсэн.
2.4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 44 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгтгэн тайлан танилцуулгыг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 03/525 тоот албан бичгээр хүргүүлэв. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн эцсийн биелэлт салбарын хэмжээнд нэгтгэн авч үзвэл гэрээний гүйцэтгэл 81.2 хувьтай үнэлэгдсэн байна. Аймаг, нийслэлийн Засаг дарга нар гэрээний хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн байна.
2.5	Сайдын тушаал, Сайдын зөвлөлийн хуралдаанаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан Чанар: Холбогдох эрх зүйн актыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмж, холбогдох арга хэмжээний саналыг ТЕЗ-д танилцуулсан байна.	ХНХСайдын 2023 оны А тушаалын жилийн эцсийн хэрэгжилтийг ТЗУГ-с тайланг ирүүлээгүй болно. /ХНХСайдын тушаалын хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 2023 оны 12 дугаар сарын 11-ний дотор ирүүлэхийг ТЗУГ-т дотоод албан бичгээр хүргүүлсэн болно./ ХНХСайдын 2023 оны А тушаалын жилийн эцсийн хэрэгжилтийг ТЗУГ-с тайланг ирүүлээгүй болно. /ХНХСайдын тушаалын хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 2023 оны 12 дугаар сарын 11-ний дотор ирүүлэхийг ТЗУГ-т дотоод албан бичгээр хүргүүлсэн болно./ ГБХНХ-ын сайдын 2024 оны А тушаалын хэрэгжилтэд 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжийг боловсруулах зорилгоор хэрэгжилтийн тайлан мэдээллийг ирүүлэх Төрийн

					захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагчтай харилцан уялдаатай ажиллаж байна.
2.6	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан Чанар: Холбогдох эрх зүйн актыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмж, холбогдох арга хэмжээний саналыг ТШЗ-д танилцуулсан байна.	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 71.2% хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ. 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг авч үзвэл: • “зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 100 хувьтай -212; • зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарсан 70.0 хувьтай -2; • “зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны жил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн 50.0 хувьтай 2; • зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа 30.0 хувьтай 3; • зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй -0 хувьтай 81 тушаал байна; • Тайлант хугацаанд гарсан 314 тушаалаас дугаар алгасч олгосон 14 тушаал байна. 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд 02 дугаар сарын 01-ний дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдхээр тайлан мэдээг ТЗУГ-аас авахаар хүлээгдэж байна.
2.7	Харьяа агентлаг, төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 18 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ТЗУГ-т хүргүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ХНХЯ-ны харьяа 4 агентлаг, 3 төв Ахмадын холбоо, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн байгууллагын гүйцэтгэлийн

			дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.		төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. <table><tr><th>№</th><th>Нэр</th><th>Хэрэгж илтийн хувь</th></tr><tr><td colspan="3">1.Агентлаг</td></tr><tr><td>1</td><td>Нийгмийн даатгалын ерөнхий газар</td><td>92.3</td></tr><tr><td>2</td><td>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар</td><td>80.7</td></tr><tr><td>3</td><td>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар</td><td>70.6</td></tr><tr><td>4</td><td>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар</td><td>65.8</td></tr><tr><td colspan="3">2. Харьяа байгууллага ,</td></tr><tr><td>1</td><td>БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв</td><td>86.9</td></tr><tr><td>2</td><td>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт</td><td>81.7</td></tr><tr><td>3</td><td>Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор</td><td>80.2</td></tr><tr><td>4</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв</td><td>76.1</td></tr></table>	№	Нэр	Хэрэгж илтийн хувь	1.Агентлаг			1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	92.3	2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	80.7	3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	70.6	4	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	65.8	2. Харьяа байгууллага ,			1	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	86.9	2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт	81.7	3	Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	80.2	4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	76.1
№	Нэр	Хэрэгж илтийн хувь																																				
1.Агентлаг																																						
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	92.3																																				
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	80.7																																				
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	70.6																																				
4	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	65.8																																				
2. Харьяа байгууллага ,																																						
1	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	86.9																																				
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт	81.7																																				
3	Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор	80.2																																				
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	76.1																																				
2.8	Яамны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 20 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ТЗУГ-т хүргүүлсэн байна.	ХНХЯ-ны нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг <table><tr><th>№</th><th>Нэгж</th><th>Биелэлтийн хувь</th></tr><tr><td>1</td><td>Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>96.6</td></tr><tr><td>2</td><td>Бодлого төлөвлөлтийн газар</td><td>96.4</td></tr><tr><td>3</td><td>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар</td><td>95.6</td></tr><tr><td>4</td><td>Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>95.5</td></tr><tr><td>5</td><td>Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>95.5</td></tr><tr><td>6</td><td>Салбарын хяналтын газар</td><td>94.4</td></tr><tr><td>7</td><td>Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>92.8</td></tr><tr><td>8</td><td>Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>90.6</td></tr><tr><td>9</td><td>Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>83.5</td></tr><tr><td>10</td><td>Төрийн захиргааны удирдлагын газар</td><td>84.8</td></tr></table> журам”-ын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлээ.	№	Нэгж	Биелэлтийн хувь	1	Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	96.6	2	Бодлого төлөвлөлтийн газар	96.4	3	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	95.6	4	Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	95.5	5	Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	95.5	6	Салбарын хяналтын газар	94.4	7	Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	92.8	8	Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	90.6	9	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	83.5	10	Төрийн захиргааны удирдлагын газар	84.8
№	Нэгж	Биелэлтийн хувь																																				
1	Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	96.6																																				
2	Бодлого төлөвлөлтийн газар	96.4																																				
3	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	95.6																																				
4	Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	95.5																																				
5	Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	95.5																																				
6	Салбарын хяналтын газар	94.4																																				
7	Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	92.8																																				
8	Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	90.6																																				
9	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	83.5																																				
10	Төрийн захиргааны удирдлагын газар	84.8																																				

2.9	Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан Чанар: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	ХНХЯамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 хэсэг зорилт, арга хэмжээний нийт 144 арга хэмжээ туссан байна. Үүнээс 83 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 30 арга хэмжээ, 70 хувьтай 10 арга хэмжээ, 50 хувьтай 3 арга хэмжээ, 30 хувьтай 6 арга хэмжээ, хугацаа болоогүй 11 арга хэмжээ, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна. Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо хугацаа болоогүй арга хэмжээг оруулан тооцоогүй болно. Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилийн байдлаар 91.2 хувьтай үнэлэгдлээ.
2.10	Ахмадын холбоо ТББ-ын гэрээний үнэлгээ		Тоо, хэмжээ: Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан Чанар: Холбогдох эрх зүйн актыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.	Үнэлгээний тайлан, зөвлөмж, холбогдох арга хэмжээний саналыг ТЕЗ-д танилцуулсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Монголын ахмадын холбоотой 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/02 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан. Тус гэрээний хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчаас 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээнд зардалд нийт 61.7 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна. Монголын ахмадын холбооны 2024 оны гэрээний /төлөвлөгөөний/ эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2024 оны төлөвлөгөөнд туссан нийт 6 зорилтын 20 арга хэмжээний биелэлт 85.8 хувьтай байсан.

					2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагуудад танилцуулан, тус байгууллагад хүргүүлж ажилласан. Монголын Ахмадын холбоотой хамтран ажиллах 2024 оны гэрээний жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэхээр гэрээний тайлан мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор хүлээн авч, ажиллаж байна.
3	Зорилт 3. Байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт, үнэлгээ хийх				
3.1	Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийнэ.		Батлагдсан удирдамж, өргөдлийн хүрээнд холбогдох эрх зүйн актыг үндэслэн хяналт, шалгалт хийнэ	Шалгалтын тайлан, зөвлөмж, холбогдох арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулсан байна.	-Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төв, Авлигатай тэмцэх газарт иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн хүний нөөц, хүнсний эрүүл ахуй, хүүхдийн мэдээллийн асуудлаар, “Найрамдал” цогцолборын цахим бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Өргөдлийн хүрээнд асуудлыг судлан хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг засч, дахин гаргахгүй байх талаар зөвлөмж, чиглэлийг албан бичгээр тус тус хүргүүлж ажиллалаа.
3.2	Иргэдээс яам, харьяа агентлаг, төв, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэнд үнэлгээ хийнэ		Холбогдох эрх зүйн актыг үндэслэн үнэлгээ хийнэ	Үнэлгээний тайлан, зөвлөмж, холбогдох арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулсан байна.	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад тус салбарын төрийн байгууллага, албан тушаалтанд 2023 онд ирүүлсэн өргөдөл, гомдолд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлэх албан бичгийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийх ажлын удирдамж, заавар”-ыг батлуулан ажиллалаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас албан бичгээр хариу хүргүүлсэн нийт 464 өргөдөл, гомдлын 274 буюу 59 хувийг, харьяа агентлаг, байгууллагуудын хэмжээнд 83.9 хувь буюу 18336 өргөдөл, гомдлыг бүрэн шийдвэрлэж ажилласан байна. Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн дарга нар

					өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах шаардлагатай байна.
4	Зорилт 4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах				
4.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллах.		Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”	- ХНХ-ын салбарын харьяа төсөвт байгууллага, тусгай сангуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавин, зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна.	ГБХНХЯ-болон харьяа ХБХХЕГ, ХАБЭМТ, ХНХСҮСИ, БНСУ дахь ХНХ-ын үйлчилгээний төв, НДЕГ, ХХҮЕГ, ХГБХХЕГ газар болон харьяа НДГ, ХХҮГ, ХХҮХ, ХГБХГ зэрэг нийт 117 байгууллагын 2024 оны 7-8 дугаар сарын байдлаарх 215 шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн системд мэдээлэл байршуулсан байдал, тайлагналтад 2024 оны 8 дугаар сарын 29 болон 9 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд дотоод аудит хийж гүйцэтгэсэн. Шилэн дансны мэдээлэл байршуулалтад дотоод аудит хийсэн тухай танилцуулгыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 12/796 дугаар албан бичгээр НДЕГ, ХХҮЕГ, ХБХХЕГ, ХГБХХЕГ, ХАБЭМТ, ХНХСҮСИ-д зэрэг байгууллагуудад хүргүүлсэн. Уг албан бичигт Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, алдаа дутагдал давтан гаргасан албан хаагчдад хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах талаар тусгасан.
4.2	Төрийн аудитын байгууллага болон дотоод аудит, хяналт шалгалтаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн		ҮАГ, Сангийн яам, Дотоод аудит, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага	Үндэсний аудитын газар, Сангийн яам, дотоод аудит, хяналт шалгалтаар харьяа	Үндэсний аудитын газраас 2024 оны 2 дугаар сард ХХҮЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ХХҮЕГ-аас Үндэсний

	мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, уялдаа холбоог хангах, дүн шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тайлагнах			байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тухай бүр тайлагнаж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна	аудитын газрын fas.audit.mn санхүүгийн тайлангийн аудитын системд оруулсныг хянан баталгуулсан. -Үндэсний аудитын газраас “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг ГБХНХЯ, НДЕГ-т хийсэн бөгөөд аудитын ажлын хэсэгтэй шууд харьцан ажиллах, шаардсан мэдээллийг холбогдох газар, хэлтэс, ажилтнуудаас шуурхай авч, судалгаа, тайланг нэгтгэн тухай бүр нь ажлын хэсэгт мэйл хаяг болон viber-ээр хүргүүлэн ажилласан. Үндэсний аудитын газраас “Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгээд, 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 08/2141 дүгээр албан бичгээр аудитын тайлангийн төсөлд санал авахаар ирүүлсэн. Уг тайлангийн төслийг Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газарт хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга нараар хянуулан ҮАГ-т 2024-11-13-ны өдрийн 03/ 1227 дугаар албан бичгээр тайлангийн төсөлд санал хүргүүлсэн. Мөн ҮАГ-аас дээрх аудиттай холбогдуулан 2024-11-14-нд ирүүлсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн жагсаалтыг Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газар, газрын дарга, ТНБД-д тус тус танилцуулж, албан шаардлагын төслөөс 2 асуудлыг хасах хүсэлтэй байгааг уламжилсан албан бичгийг газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга нараар хянуулан 2024-11-25-ны өдрийн 03/ 1357 дугаар албан бичгээр ҮАГ-т хүрүүлэх арга хэмжээ авч ажилласан.
4.3	Дотоод аудитын хорооноос баталсан төлөвлөгөөний хүрээнд төсөвт байгууллага, тусгай сангуудын		Төсвийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор	- Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг ТЕЗ-ын баталсан удирдамжийн	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/33 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх 2024 оны ажлын төлөвлөгөө”-ний дагуу ГБХНХ-ын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/18 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд

	үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтад дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж, цаашид авах арга хэмжээний санал гаргах.		батлагдсан “Дотоод аудитын дүрэм”	хүрээнд гүйцэтгэсэн байна. - Дотоод аудитын үр дүнг Дотоод аудитын хороо болон ТЕЗ-д танилцуулсан байна. - Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 он, 2023 он болон 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, орлого, зарцуулалт, үр дүн, дотоод хяналтын үйл ажиллагаа, Нийгмийн халамжийн сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудит хийж гүйцэтгэсэн. Нэгдсэн танилцуулгыг Дотоод аудитын хороонд танилцуулахаар бэлтгэж байна.
--	---	--	--	---	---